МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 10 сарын 20 өдөр Дугаар А/587 Алтай хот

Замын нээлтийн үйл ажиллагааг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар 32.7 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын бэлтгэл хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2020 оны 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Байдраг-Алтай чиглэлийн 126,7 км замын нээлтийн үйл ажиллагааг хамтран зохион байгуулсан ажлын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ж.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

2.Байдраг-Алтай чиглэлийн 126,7 км замын ажлыг гүйцэтгэсэн "Макс рөүд" ХХК-ийн захирал, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Тод манлай уяач, Баян-Уул сумын харьяат Д.Ганбаатарыг шагнаж урамшуулсугай.

3.Замын нээлт, шагнал урамшуулалд шаардагдсан 5498500 (таван сая дөрвөн зуун ерэн найман мянга таван зуун) төгрөгийг Засаг даргын бэлтгэл хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ж.Мөнхцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ГАНБАТ

C:/My Documents/ZAHNR-3A-4 doc

0201001527